



ДОРНОД АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР



Formatted: Font: (Default) Arial, Bold, Mongolian (Cyrillic)

Field Code Changed

## САНХҮҮГИЙН АУДИТЫН ТАЙЛАН

Field Code Changed

Хэрлэн сумын 2019 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

Аудитын код: ДОА-2020/12/СТА-ТТЗ

Цахим хуудас: [www.audit.mn](http://www.audit.mn)

Чойбалсан хот

2020 он

Дорнод аймаг дахь Төрийн аудитын газрын дарга бөгөөд тэргүүлэх аудитор: Б.Болортуул

Утас:7058-4203 Цахим хаяг: Bolortuulb@audit.gov.mn

Аудитын менежер: В.Цэнгэлмаа

Утас:7058-4204 Цахим хаяг: Tsengelmaav@audit.gov.mn

Ахлах аудитор: Д.Нармандах

Утас:7058-4207 Цахим хаяг: Narmandakhd@audit.gov.mn

Formatted: Default Paragraph Font, Font: (Default) +Body (Calibri)

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

Field Code Changed

Field Code Changed



Хэрлэн сумын 2019 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, жилийн төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

**Агуулга**

1. Аудитын гэрчилгээ.....	33
2. Аудитын тайлан .....	54
2.1. Оршил.....	54
2.2. Аудит хийх үндэслэл, зорилго, талуудын хүлээх үүрэг, хариуцлага .....	54
2.3. Аудитын явцад мөрдсөн бодлого, журам, арга зүй, шалгуур үзүүлэлт .....	54
2.4. Нягтлан бодох бүртгэлийн бодлого, үйл ажиллагаа болон дотоод хяналттай холбоотой хүчин зүйлсийн үнэлгээ.....	66
2.5. Төлөвлөлтийн шатанд тодорхойлсон эрсдэл, түүнийг үнэлсэн байдал .....	66
2.6. Материаллаг байдлын суурь сонгосон үндэслэл, тайлбар .....	66
2.7. Аудитын явцад хэрэгжүүлсэн горим сорил, түүний үр дүн .....	66
2.8 Санхүүгийн нэгтгэсэн тайлангийн үзүүлэлт .....	87
2.8.1 Мөнгөн хөрөнгө.....	87
2.8.2 Богино хугацаат хөрөнгө оруулалт.....	98
2.8.3 Авлага.....	99
2.8.4 Урьдчилгаа.....	99
2.8.5 Урт хугацаат хөрөнгө оруулалт.....	99
2.8.6 Бараа материал .....	99
2.8.7 Үндсэн хөрөнгө .....	100
2.8.8 Өр төлбөр.....	100
2.8.9 Засгийн газрын хувь оролцоо .....	111
2.9 Төсвийн гүйцэтгэлийн талаарх тайлбар, тодруулга .....	111
2.10. Дараагийн аудитаар авч үзэх буюу анхаарал татахуйц бусад чухал асуудал .....	134
2.11. Шилэн дансны мэдээлэл .....	134
2.12. Өмнөх зөвлөмжийн хэрэгжилтийн талаарх тайлбар, тодруулга .....	134
2.13. Дүгнэлтийн хэлбэр, үндэслэл .....	134
3. Менежментийн захидал.....	144
3.1 Дотоод хяналттай холбоотой асуудал.....	144
4. Аудит хийсэн санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайлан.....	154
4.1 Аудит хийсэн санхүүгийн нэгтгэсэн байдлын тайлан .....	154
4.2 Аудит хийсэн санхүүгийн нэгтгэсэн үр дүнгийн тайлан .....	164
4.3 Аудит хийсэн нэгтгэсэн мөнгөн гүйлгээний тайлан .....	194
4.4 Аудит хийсэн нэгтгэсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан .....	214
4.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан .....	224
4.6 Аудит хийсэн нэмэлт санхүүжилтийн тайлан .....	244
5.Аудитын явцад илэрсэн алдаа, зөрчлийн жагсаалт .....	254

Formatted: Mongolian (Cyrillic)

Formatted: Font: Not Bold, Check spelling and grammar

Formatted: Mongolian (Cyrillic)



Хэрлэн сумын 2019 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, жилийн төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

**Товчилсон үгийн жагсаалт**

АДБОУС	Аудитын Дээд Байгууллагуудын Олон Улсын Стандарт
АОУС	Аудитын Олон Улсын Стандарт
УСНББОУС	Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт
ТТЗ	Төсвийн төвлөрүүлэн захирагч
ТШЗ	Төсвийн шууд захирагч
ДОА	Дорнод аймаг

## 1. Аудитын гэрчилгээ

		ХЭРЛЭН СУМЫН ЗАСАГ ДАРГА П.МӨНХТӨР ТАНАА
<b>ДОРНОД АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР</b>		
<small>21000 Дорнод аймаг, Хэрлэн сум 7-р баг ЗДТТ-ий II байр, Утас/Факс: 7058-4203</small>		
2020.03.25 № 324		
танай	-ны №	-т
<b>Аудитын гэрчилгээ</b>		
<p>Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.2, 18 дугаар зүйлийн 18.2, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.2-д заасны дагуу Хэрлэн сумын 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд санхүүгийн тайлангийн аудит хийв.</p>		
<b>Зөрчилгүй санал дүгнэлт</b>		
<p>Хэрлэн сумын 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх нэгтгэсэн санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээ болон төсвийн гүйцэтгэлийн тайланг материаллаг зүйлсийн хувьд Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, УСНББОУС-д нийцүүлж, Сангийн Сайдын баталсан бодлого, журам, зааврын дагуу үнэн, бодитой, шударга илэрхийлсэн тул зөрчилгүй санал дүгнэлт гаргаж байна.</p>		
<b>Санал дүгнэлтийн үндэслэл</b>		
<p>Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагуудын нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчим, стандарт болон Аудитын Олон Улсын стандартад нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан Санхүүгийн тайлангийн аудитын журам, зааврын дагуу гүйцэтгэсэн. Эдгээр нь санхүүгийн тайлан материаллаг буруу илэрхийллээс ангид эсэх талаар үндэслэлтэй баталгаа олж авах зорилгоор аудитыг төлөвлөж, гүйцэтгэхийг шаарддаг.</p>		
<p>Аудитаар Хэрлэн сумын төсвийн гүйцэтгэлийн 2019 оны жилийн эцсийн нэгтгэсэн төсвийн гүйцэтгэл, санхүүгийн тайлан дахь үлдэгдэл, ажил гүйлгээний дүн хэмжээ болон илчлэл тодруулга, тус байгууллагад мөрдөж байгаа нягтлан бодох бүртгэлийн бодлого, бүртгэл хөтлөлт, программ хангамж, дотоод хяналтын систем болон удирдлагын хийсэн томоохон тооцооллыг шалгаж, аудитын санал дүгнэлтийг дэмжих нотлох зүйлсийг хангалттай цуглуулсан.</p>		
<p>Бидний хийсэн аудит тус санхүүгийн тайлан, тодруулгад санал дүгнэлт өгөх хангалттай, зохистой үндэслэлийг бүрдүүлсэн бөгөөд аудитын дүнд үндэслэсэн санал, зөвлөмжийг аудитын тайланд тусгасан болно.</p>		
113520260		



Хэрлэн сумын 2019 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, жилийн төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

**Үүрэг, хариуцлага**

Төсвийн захирагч нь Төсвийн тухай хуулийн 54 дүгээр зүйлийн 54.3-д заасны дагуу тайлант хугацааны санхүүгийн тайлан, тодруулгыг Нягтлан бодох бүртгэлийн болон Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандарт, түүнтэй нийцүүлэн Сангийн Сайдын баталсан журам, зааврын дагуу бэлтгэж, тайлагнах үүрэгтэй.

Аудитын дээд байгууллагуудын нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчим, стандарт болон Аудитын олон улсын стандартын дагуу аудит хийж, жилийн эцсийн төсвийн гүйцэтгэл, санхүүгийн тайланд санал дүгнэлт өгөх нь Төрийн аудитын байгууллагын үүрэг юм.

ДАРГА БӨГӨӨД  
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР  Б.БОЛОРТУУЛ



## 2. Аудитын тайлан

### 2.1. Оршил

Хэрлэн сумын 2019 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, жилийн төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын дүн, дүгнэлтийг төсвийн төвлөрүүлэн захирагч П.Мөнхтөр танд танилцуулж байна.

Энэхүү тайланд үйлчлүүлэгчийн санхүү, нягтлан бодох бүртгэл, дотоод хяналтын системд хийсэн үнэлгээний тойм, аудитын явцад илрүүлсэн зүйлс, гаргасан шийдлүүд, анхаарал хандуулахуйц залруулаагүй материаллаг болон материаллаг бус алдаа зөрчил зэрэг аудитын үр дүнгийн талаарх тайлбар, тодруулга, аудитын санал дүгнэлтийн хэлбэр, түүний үндэслэлийн талаар тус тус хураангуйлан тэмдэглэв.

Аудитын дүнд үндэслэсэн үйлчлүүлэгчийн нягтлан бодох бүртгэл, тайлагнал, дотоод хяналтын системийг боловсронгуй болгох зөвлөмжүүдийг Менежментийн захидалд тусгасан болно.

### 2.2. Аудит хийх үндэслэл, зорилго, талуудын хүлээх үүрэг, хариуцлага

Бид Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.2.4, 18 дугаар зүйлийн 18.2, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.2-т заасны дагуу Хэрлэн сумын 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болгосон санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Хэрлэн сумын 2019 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэл Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль болон УСНББОУС, түүнд нийцүүлэн гаргасан төсвийн байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлого, заавар, журмын дагуу үнэн зөв, шударга илэрхийлэгдсэн эсэхэд дүгнэлт өгөх нь энэхүү аудитын зорилт байв.

Төсвийн төвлөрүүлэн захирагч санхүүгийн нэгтгэсэн тайлан, жилийн төсвийн гүйцэтгэлийн тайлангаа Төсвийн тухай хууль болон УСНББОУС, түүнд нийцүүлэн баталсан төсвийн байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлого, журмын дагуу үнэн зөв, бодитой бэлтгэх үүрэгтэй.

Харин тухайн санхүүгийн нэгтгэсэн тайлан, жилийн төсвийн гүйцэтгэлийг дээрх хууль болон бодлого, журмын дагуу материаллаг алдаагүй, үнэн зөв, шударга илэрхийлсэн эсэхэд санал дүгнэлт өгөх нь Төрийн аудитын байгууллагын үүрэг юм.

Аудитыг 2020 оны 03 дугаар сарын 15-наас 2020 оны 03 дугаар сарын 23-ны хооронд гүйцэтгэж, аудитын тайланг 2020 оны 03 дугаар сарын 25-ны өдөр эцэслэн баталгаажуулж, төсвийн төвлөрүүлэн захирагчид хүргүүлэхээр төлөвлөн, ахлах аудитор Д.Нармандах гүйцэтгэв.

Хэрлэн сумын 2019 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, жилийн төсвийн гүйцэтгэлийн тайланг Дорнод аймаг дахь Төрийн аудитын газарт 2020 оны 03 дугаар сарын 04-ний өдрийн 1/133 дугаар албан бичгээр ирүүлсэн байна.

### 2.3. Аудитын явцад мөрдсөн бодлого, журам, арга зүй, шалгуур үзүүлэлт

Аудитын явцад АДБОУС, АОУС, нийтээр хүлээн зөвшөөрсөн бусад зарчимд тулгуурласан төрийн аудитын байгууллагын санхүүгийн тайлангийн аудитын талаарх бодлого, арга зүйг мөрдөж ажиллав.

Дээрх стандарт, зарчимд нийцүүлж Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан Төрийн аудитын байгууллагаас санхүүгийн тайланд аудит хийх журам, түүнд тусгасан үе шатны ажлыг гүйцэтгэн, шат шатны чанарын хяналт хийж, холбогдох ажлын баримт материалаар баталгаажуулсан болно.

ДОА-2020/12/СТА-ТТЗ

Аудитыг Нягтлан бодох бүртгэлийн нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчмууд, УСНББОУС, Төсвийн тухай хууль болон Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийг гол шалгуур болгож, батлагдсан төлөвлөгөө, хөтөлбөрийн дагуу хэрэгжүүлэв.

#### **2.4. Нягтлан бодох бүртгэлийн бодлого, үйл ажиллагаа болон дотоод хяналттай холбоотой хүчин зүйлсийн үнэлгээ**

Бид санхүүгийн тайланд материаллаг алдаа байхгүй гэдгийг нягтлах үүднээс үйлчлүүлэгчийн нягтлан бодох бүртгэлийн бодлого, үйл ажиллагаа болон дотоод хяналтыг шаардлагатай гэж үзсэн хэмжээгээр дахин хянасан. Энэ нь материаллаг алдаа гарахаас хамгаалах ёстой гол бодлого, хяналтуудыг тодруулах, судлах зорилготой юм.

Хэрлэн сумын төсвийн төвлөрүүлэн захирагчийн санхүүгийн үйл ажиллагаанд ашиглаж байгаа нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь холбогдох стандарт, журамд өөрчлөлт гараагүй байна.

Хэрлэн сумын төсвийн төвлөрүүлэн захирагчийн үндсэн үйл ажиллагаа, санхүүгийн дотоод хяналтын эрсдэлийг төлөвлөлтийн үе шатанд дунд гэж үнэлсэн бөгөөд гүйцэтгэлийн шатанд дахин хянахад дотоод хяналт үр нөлөөтэй гэж үзлээ.

Аймгийн Засаг даргын дэргэдэх Санхүү хяналт, аудитын алба нь 2019 онд Халхгол сумын төвлөрүүлэн захирагчийн санхүүгийн үйл ажиллагаанд дотоод аудит хийгээгүй байна.

#### **2.5. Төлөвлөлтийн шатанд тодорхойлсон эрсдэл, түүнийг үнэлсэн байдал**

Аудитын явцад Хэрлэн сумын төсвийн төвлөрүүлэн захирагчийн бэлтгэсэн санхүүгийн нэгтгэсэн тайлан, жилийн төсвийн гүйцэтгэл нь материаллаг хэмжээний алдаатай илэрхийлэгдээгүй гэсэн үндэслэлтэй нотолгоо олж авахын тулд байгууллагын гадаад дотоод орчин, дотоод хяналтыг судалж, санхүүгийн нэгтгэсэн тайлан, жилийн төсвийн гүйцэтгэлийн тайлантай холбоотой эрсдэлтэй асуудлыг илрүүлж, үнэлсэн.

Аудитыг төлөвлөх үе шатанд эрсдэлийн үнэлгээний урьдчилсан горим хэрэгжүүлэн 16 эрсдэлтэй асуудал тодорхойлж, эрсдэлийн үнэлгээний дүнд үндэслэн 16 асуудалд нарийвчилсан горим сорил хэрэгжүүлэхээр төлөвлөж баталгаажуулсан болно.

#### **2.6. Материаллаг байдлын суурь сонгосон үндэслэл, тайлбар**

Аудитыг төлөвлөх болон гүйцэтгэх үе шатны материаллаг байдлын түвшинг АДБОУС 1320, АОУС 320-ын дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр зардлыг сонгов.

Төлөвлөлтийн шатанд материаллаг байдлын түвшнийг зардлын 1 хувь буюу 284.5 сая төгрөгөөр тогтоов.

Гүйцэтгэлийн үе шатанд төлөвлөлтийн шатанд тогтоосон материаллаг байдлын түвшнийг өөрчлөх шаардлагагүй гэж үзсэн болно.

#### **2.7. Аудитын явцад хэрэгжүүлсэн горим сорил, түүний үр дүн**

Аудитын явцад хэрэгжүүлэх горим сорилыг төсвийн шатлалд хамаарах байгууллага, нэгж тус бүрээр төлөвлөж хэрэгжүүлсэн бөгөөд аудитын дүн, дүгнэлтийг нэгтгэсэн байдлаар үнэлж, гаргалаа.

Төсвийн төвлөрүүлэн захирагчийн 2019 оны санхүүгийн нэгтгэсэн тайланд харьяа 27 төсвийн байгууллага, 2 орон нутгийн өмчит аж ахуйн нэгж, 2 тусгайн сангийн нийт 31 санхүүгийн тайлан нэгтгэгдсэнээс аудитад хамрагдсан 27 байгууллага, итгэл үзүүлсэн 4 байгууллага байна.

Formatted: Font: Bold, Small caps

Field Code Changed

Formatted: Font: Bold, Small caps

Хэрлэн сумын 2019 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, жилийн төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

Аудитад хамрагдсан харьяа байгууллагын санхүүгийн тайланд “Зөрчилгүй” 21, “Хязгаарлалттай” 1 дүгнэлт өгч, 5 байгууллагын тайланг түүвэрт хамруулан шалгаж, илэрсэн асуудлыг нэгтгэсэн тайланд тусгалаа.

Хэрлэн сумын 2019 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитаар нийт 429.7 сая төгрөгийн алдаа, зөрчил илрүүлснээс 426.7 сая төгрөгийн 1 алдааг аудитын явцад залруулж, ----- 3.0 сая төгрөгийн алдаа, зөрчил илрүүлсэнд 1 албан шаардлага хүргүүлсэн.

Санхүүгийн нэгтгэсэн тайлангийн залруулга

Төвлөрүүлэн захирагчийн санхүүгийн нэгтгэсэн тайланг нэгтгэхдээ харьяа байгууллагуудын аудит хийсэн санхүүгийн тайлангаас зөрүүтэй нэгтгэсэн үзүүлэлт байхгүй байна.

Төвлөрүүлэн захирагчид хүргүүлсэн акт, албан шаардлага

Төсвийн төвлөрүүлэн захирагчийн ангилалдаагүй зардлаас 3,0 сая төгрөгийн шинэ жилийн бэлэг худалдан авч тараасан байна. Энэ нь Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.5 дахь хэсэгт “батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах” гэж заасантай нийцэхгүй, санхүүгийн тайлангийн үнэн зөв байдал гэсэн батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Шийдвэрлэсэн: Албан шаардлага хүргүүлээ.

Төвлөрүүлсэн захирагчийн дотоод хяналттай холбоотой алдаа, зөрчилд өгсөн 1 зөвлөмжийг менежментийн захидалд дурдсан болно.

Харьяа байгууллагуудын санхүүгийн тайлангийн залруулга

Тус төвлөрүүлэн захирагчийн харьяа байгууллагуудын санхүүгийн тайланд нийт 754,939.8 мянган төгрөгийн залруулга хийлээ. Үүнд

- Хэрлэн сумын Засаг даргын тамгын газар: Зардлын ангилал хооронд 19,911.0 мянган төгрөгийг гүйлгэн тайлагнасан, 19,860,0 мянган төгрөгийн нөөцийн барааг орлогод тусгаагүй алдааг санхүүгийн тайланд залруулсан.
- Хэрлэн сумын Хан уул цогцолбор сургууль: Тайлант хугацааны 21,257.23 мянган төгрөгийн элэгдлийг дутуу тооцсон алдааг санхүүгийн тайланд залруулга хийлгэсэн.

гүйлгэн тайлагнасан, дахин үнэлэгдсэн барилгын ашиглагдах жилийг санхүүгийн программд буруу оруулснаар тайлант үеийн 200,066.8 мянган төгрөгийн элэгдэл буруу тооцсон алдааг санхүүгийн тайланд залруулсан.

- Хэрлэн сумын 8 дугаар сургууль: Зардлын ангилал хооронд 80,006.1 мянган төгрөгийг гүйлгэн тайлагнасан, тайлант хугацааны 14,793.0 мянган төгрөгийн элэгдлийг дутуу тооцсон, цалингийн 123.10 мянган төгрөгөөр өглөгийг тусгуулан, 20,191.5 мянган төгрөгийн зардал бууруулах бичилт хийсэн алдааг санхүүгийн тайланд залруулсан.
- Хэрлэн сумын 12 дугаар сургууль: Хэрлэн сумаас хийж өгсөн гэрэлтүүлгийг 6,000.0 мянган төгрөгийн н үндсэн хөрөнгийг эрэлтүүлгийг бусад үндсэн хөрөнгөөр бүртгэж тайлагнасан алдааг санхүүгийн тайланд залруулсан.

Хэрлэн сумын 2019 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, жилийн төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

- Хэрлэн сумын 1 дүгээр цэцэрлэг: Зардлын ангилал хооронд 7,835.0 мянган төгрөгийг гүйлгэн тайлагнасан, 500.0 мянган төгрөгийн үндсэн хөрөнгийг зардлаар бүртгэсэн алдааг санхүүгийн тайланд залруулсан.
  - Хэрлэн сумын 2 дүгээр цэцэрлэг: Зардлын ангилал хооронд 11,210.7 мянган төгрөгийг гүйлгэн тайлагнасан, тайлант үеийн 20,006.8 мянган төгрөгийн элэгдэл буруу тооцсон алдааг санхүүгийн тайланд залруулсан.
  - Хэрлэн сумын 5 дүгээр цэцэрлэг: Акталсан 2,369.5 мянган төгрөгийн бараа материалыг данс бүртгэлээс хасаагүй алдааг санхүүгийн тайланд залруулсан.
  - Хэрлэн сумын 7 дүгээр цэцэрлэг: Зардлын ангилал хооронд 1,329.40 мянган төгрөгийн гүйлгэн тайлагнасан алдааг санхүүгийн тайланд залруулсан.
  - Хэрлэн сумын 8 дүгээр цэцэрлэг: Дулуу тооцсон 1,894.1 мянган төгрөгийн элэгдэл, 4,990.7 мянган төгрөгийн гэрэлтүүлгийг үндсэн хөрөнгөөр бүртгэсэн алдааг санхүүгийн тайланд залруулсан.
  - Хэрлэн сумын 10 дүгээр цэцэрлэг: Санхүүгийн байдлын тайланд 196,045.0 мянган төгрөгийн газрыг биет бус хөрөнгөд оруулаагүй, үндсэн хөрөнгийн хэсэгт оруулж тайлагнасан алдааг санхүүгийн тайланд залруулсан.
  - Хэрлэн сумын 11 дүгээр цэцэрлэг: Тайлант оны үр дүнгийн дүн өмчийн өөрчлөлтийн тайланг 1,666.6 мянган төгрөгөөр зөрүүтэй илэрхийлсэн алдааг санхүүгийн тайланд залруулсан.
  - Хэрлэн сумын 12 дүгээр цэцэрлэг: Зардлын ангилал хооронд 2,791.0 мянган төгрөг гүйлгэн тайлагнасан, –бараа материалын 76,281.5 мянган төгрөгийн оны эхний үлдэгдлийг тусгажгүй тайлант оны өрлөгө зарлагыг тусгасан агуй алдааг санхүүгийн тайланд залруулсан.
- Хэрлэн сумын 15 дүгээр цэцэрлэг: Зардлын ангилал хооронд 58,994.2 мянган төгрөгийг гүйлгэн тайлагнасан алдааг санхүүгийн тайланд залруулсан.

• **Хязгаарлалттай**

**2.8 Санхүүгийн нэгтгэсэн тайлангийн үзүүлэлт**

**2.8.1 Мөнгөн хөрөнгө**

~~Мөнгөн хөрөнгийн оны эхний үлдэгдэл 4,320.6 тэрбум, эцсийн үлдэгдэл 4,625.7 тэрбум төгрөг болж, 305.1 тэрбум төгрөгөөр өссөн байна. Мөнгөн хөрөнгийн эхний үлдэгдэл 328.8 сая, эцсийн үлдэгдэл 385.6 сая төгрөг болж, 56.8 сая төгрөгөөр өссөн байна.~~

Хүснэгт №1. Мөнгөн хөрөнгийн үлдэгдэл /сая төгрөг/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өсөлт (+), Бууралт (-)	Дүнд эзлэх хувь
<del>Касст байгаа бэлэн мөнгө</del>	0.1	0.1	-	
<del>Банканд байгаа бэлэн мөнгө</del>	328.7	385.5	56.8	
<del>Замд яваа мөнгөн хөрөнгө</del>				
<del>Хадгаламж</del>				
<b>Дүн</b>	328.8	385.6	56.8	100

Мөнгөн хөрөнгийн үлдэгдэлд байгаа 379.7-8 сая төгрөг төрийн сангийн харилцах дансанд, 5.8 сая төгрөг арилжааны банкны дансанд байршиж байна.

## 2.8.2 Богино хугацаат хөрөнгө оруулалт

Богино хугацаат хөрөнгө оруулалт дансанд гүйлгээ хийгдээгүй байна.

## 2.8.3 Авлага

Авлага ~~Мөнгөн хөрөнгийн оны эхний үлдэгдэл 4,320.6 тэрбум, эцсийн үлдэгдэл 4,625.7 тэрбум төгрөг болж, 305.1 тэрбум төгрөгөөр өссөн байна.~~ дансны эхний үлдэгдэл 829.2 сая, эцсийн үлдэгдэл 897.6 сая төгрөг болж, 68.4 сая төгрөгөөр өссөн байна.

Хүснэгт №2 Авлагын үлдэгдэл

/сая төгрөг/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өсөлт (+), Бууралт (-)
Ажиллагчидтай холбогдсон авлага	3.4	0	-3.4
Бусад авлага	825.38	897.6	+71.7
Зээлийн авлага	-	-	-
<b>Дүн</b>	<b>829.2</b>	<b>897.6</b>	<b>68.4</b>

Авлага дансны үлдэгдэлд тусгагдсан Сум хөгжүүлэх сангаас олгосон 3-8 жилийн насжилттай 540.7 сая төгрөгийн 34 иргэн, 8 аж ахуй нэгж байгууллагын авлагыг шийдвэрлүүлэхээр шүүхэд шилжүүлсэн байна.

Он дамжсан авлагын үлдэгдэл өндөр байгаа нь сангаас аж ахуй нэгж, иргэнд жижиг дунд үйлдвэрлэлийг дэмжихэд үзүүлэх зээл олголтын эх үүсвэр дутагдах зэрэг сөрөг үр дагавартай байна.

Formatted: Mongolian (Cyrillic)

## 2.8.4 Урьдчилгаа

Урьдчилгаа ~~Мөнгөн хөрөнгийн оны эхний үлдэгдэл 4,320.6 тэрбум, эцсийн үлдэгдэл 4,625.7 тэрбум төгрөг болж, 305.1 тэрбум төгрөгөөр өссөн байна.~~ дансанд гүйлгээ хийгдээгүй байна.

## 2.8.5 Урт хугацаат хөрөнгө оруулалт

Урт хугацаат хөрөнгө оруулалтын дансанд гүйлгээ хийгдээгүй байна.

## 2.8.6 БАРАА МАТЕРИАЛ

Бараа материалын ~~Мөнгөн хөрөнгийн оны эхний үлдэгдэл 4,320.6 тэрбум, эцсийн үлдэгдэл 4,625.7 тэрбум төгрөг болж, 305.1 тэрбум төгрөгөөр өссөн байна.~~ эхний үлдэгдэл 2,334.8 сая, эцсийн үлдэгдэл 2,724.8 сая төгрөг болж 390.0 сая төгрөгөөр өссөн байна.

Хүснэгт №3 Бараа материалын үлдэгдэл

/сая төгрөг/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өсөлт (+), Бууралт (-)
Тусгай зориулалтын материал	102.3	210.4	+108.1
Эм боох материал	2.1	18.5	+16.4
Бичиг хэргийн материал	25.9	25.4	-0.5
Аж ахуйн материал	317.1	339.2	+22.1
Сэлбэг хэрэгсэл	1.2	0.9	-0.3
Түлш, шатах тослох материал	-	3.6	+3.6
Барилгын засварын материал	0.7	3.5	+2.8
Хүнсний материал	-	-	-
Бусад хангамжийн материал	1,812.9	2,051.5	+238.6
Мал амьтад	72.5	71.8	-0.7
<b>Дүн</b>	<b>2,334.8</b>	<b>2,724.8</b>	<b>390.0</b>

Хэрлэн сумын 2019 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, жилийн төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

Бараа материалын үлдэгдэл өссөн нь байгууллагуудын хэвийн үйл ажиллагааг хангахад шаардлагатай аж ахуйн материалыг худалдан авсантай холбоотой байна.

Бараа материалын үлдэгдэлд ашиглалтгүй, байгууллагын үйл ажиллагаанд ашиглагдах боломжгүй бараа материал байхгүй байна.

## 2.8.7 Үндсэн хөрөнгө

Үндсэн хөрөнгийн ~~Мөнгөн хөрөнгийн оны эхний үлдэгдэл 4,320.6 тэрбум, эцсийн үлдэгдэл 4,625.7 тэрбум төгрөг болж, 305.1 тэрбум төгрөгөөр өссөн байна. эхний үлдэгдэл 62,721.1 сая, эцсийн үлдэгдэл 69,244,222.43 сая төгрөг болж, 6,503,501.32 сая төгрөгөөр өссөн байна.~~

Хүснэгт №4 Үндсэн хөрөнгийн үлдэгдэл /сая төгрөг/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өсөлт (+), Бууралт (-)
Барилга, байгууламж, орон сууц	39,960.4	45,045.3	+5084.9
Авто-тээврийн хэрэгсэл	1,339.7	1,617.7	+278.0
Машин тоног төхөөрөмж	3,010.5	3,269.0	+258.5
Тавилга, аж ахуйн эд хогшил	1,596.0	1,790.0	+194.0
Зам, гүүр байгууламж	2,507.9	2,732.3	+224.4
Түүх соёл, музейн дурсгалт зүйлс	1,749.5	1,805.5	+56.0
Дуусаагүй барилга байгууламж	714.2	314.2	-400.0
Номын фонд	27.8	4.5	-23.3
Бусад үндсэн хөрөнгө	3,792.8	4,618.8	+826.0
Программ хангамж	35.0	37.8	+2.8
Бусад биет бус хөрөнгө	7,987.2	7,987.2	-
<b>Дүн</b>	<b>62,721.1</b>	<b>69,244,222.43</b>	<b>+6,503,501.02</b>

Үндсэн хөрөнгө нэмэгдсэн нь улсын төсвийн хөрөнгө оруулалтаар шинээр 17, 18 дугаар цэцэрлэг, 2 дугаар сургуулийн спорт заал ашиглалтад орсонтой холбоотой байна.

“Гэрэл сэтгэмж” ОНӨҮГ-ын хөрөнгөнд бүртгэлтэй 206.0 сая төгрөгийн Найрамдал паркард байрлах эргийн хамгаалалтын байгууламж хийх, 76.4 сая төгрөгийн гэрлэн дохио, 31.8 сая төгрөгийн гудамжны гэрлийн шон байрлуулах дуусаагүй ажлуудын нийт 314.2 сая төгрөгийн хөрөнгүүд дуусаагүй барилга дансанд бүртгэлтэй байна.

## 2.8.8 Өр төлбөр

Нийт өр төлбөрийн ~~Мөнгөн хөрөнгийн оны эхний үлдэгдэл 4,320.6 тэрбум, эцсийн үлдэгдэл 4,625.7 тэрбум төгрөг болж, 305.1 тэрбум төгрөгөөр өссөн байна. эхний үлдэгдэл 265.6 сая, эцсийн үлдэгдэл 163.1 сая төгрөг болж, 102.5 сая төгрөгөөр буурсан байна.~~

Хүснэгт №5 Нийт өр төлбөрийн үлдэгдэл /сая төгрөг/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өссөн+ Буурсан -	Дүнд эзлэх хувь
<del>Богино хугацаат өр төлбөр дүн</del>	108.4	5.8	-102.5	3.5
<del>Урт хугацаат өр төлбөр дүн</del>	157.2	157.2	0.0	96.5
<b>Нийт дүн</b>	<b>265.6</b>	<b>163.1</b>	<b>102.5</b>	<b>100.0</b>

Богино хугацаат өр төлбөр буурсан нь өмнөх оны ажиллагсадтай холбоотой татвар, нийгмийн даатгалын шимтгэлийг барагдуулсантай холбоотой байна

Урт хугацаат өр төлбөрийн дансны үлдэгдэлд “Чойбалсан хөгжил” ОНӨҮГ-ын “Дорнод НАА” ОНӨААТҮГ-т өгөх хог тээврийн автомашин байна. [Уг урт хугацаат өр төлбөр нь 2005 онд Чойбалсан хөгжил ОНӨҮГ нь бие даан үйл ажиллагаа явуулж эхэлсэнтэй холбоотой үүссэн байна.](#)

### 2.8.9 Засгийн газрын хувь оролцоо

[Засгийн газрын хувь оролцоо дансны эхний үлдэгдэл](#) 59,372.8 сая, [эцсийн үлдэгдэл](#) 64,024.1 сая [төгрөг болж](#) 4,651.3 сая [төгрөгөөр өссөн](#) нь хөрөнгө оруулалтаас шалтгаалсан байна.

**Хүснэгт № 6. Засгийн газрын хувь оролцоо** /сая төгрөг/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өсөлт/+, бууралт -/	Дунд эзлэх хувь
<a href="#">Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан</a>	24,540.7	24,540.7	-	38.3
<a href="#">Хуримтлагдсан үр дүн</a>	17,128.8	21,786.1	+4,657.3	34.0
<a href="#">Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү</a>	17,703.8	17,697.3	-6.5	27.7
<a href="#">Бодлогын өөрчлөлт алдааны залруулга</a>				
<b>Дүн</b>	<b>59,372.8</b>	<b>64,024.1</b>	<b>4,651.3</b>	<b>100</b>

Formatted: Font: Arial, Font color: Auto, Mongolian (Cyrillic)

Formatted: Right, Space After: 0 pt

[Засгийн газрын оруулсан капитал](#) дансанд гүйлгээ хийгдээгүй байна.

[Бодлогын өөрчлөлт алдааны залруулга](#) дансанд гүйлгээ хийгдээгүй байна.

### 2.9 Төсвийн гүйцэтгэлийн талаарх тайлбар, тодруулга

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн ~~шууд~~ захирагч нь энэ хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

Хэрлэн сумын ИТХ-ын “2019 оны орон нутгийн төсөв батлах тухай” 17/01 дугаар тогтоолд сумын төсвийн орлогын төлөвлөгөө 2,800818.5 сая төгрөгөөр батлагдсанаас гүйцэтгэлээр 3,083.0 сая төгрөгийн орлогыг бүрдүүлж 106.3 хувиар биелсэн байна.

**Хүснэгт 2. Төвлөрүүлэх орлого** /сая төгрөг/

Орлогын төрөл	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Хувь
Орлогыг нь тухай бүр тодорхойлох боломжгүй ажил, үйлчилгээ хувиараа эрхлэгч хувь хүний орлогын албан татвар	370.8	358.8	-12.0	96.8
Бууны албан татвар	9.3	9.7	0.4	104.3
Төсвийн тухай хуулийн 23.4.9-д зааснаас бусад улсын тэмдэгтийн хураамж	796.5	718.9	-77.6	90.2

Хэрлэн сумын 2019 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, жилийн төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

Түгээмэл тархацтай ашигт малтмал ашигласны төлбөр	28.0	31.1	3.1	111.1
Суутгагчийн 10%-ийн шимтгэл	400.0	570.3	170.3	142.6
Хог хаягдлын үйлчилгээний хураамж	274.6	280.0	5.4	101.9
Хүү, торгуулийн орлого	268.7	281.3	12.6	104.7
Бусад орлого	20.0	7.6	-12.4	38.0
Хөрөнгийн орлого /хадгаламжийн хүү/	651.0	763.7	112.7	117.3
<b>Нийт дүн</b>	<b>2,899.5</b>	<b>3,083.0</b>	<b>183.5</b>	<b>106.3</b>

Нийт орлого 183.5 сая төгрөгөөр давсан нь суутгагчийн 10%-ийн шимтгэл, хадгаламжийн хүүгийн орлого давж биелсэнтэй холбоотой байна.

Улсын тэмдэгтийн хураамжийн орлого 77.6 сая төгрөгөөр тасарсан гол шалтгаан нь "Шин Шин" ХХК-ний орлого 2019 оноос Дашбалбар сумын төсөвт төвлөрдөг болсноо шалтгаалсан байна.

Тайлант онд төсвийн төвлөрүүлэн захирагчийн хэрэгжүүлэх хөтөлбөрт зориулан 20,975.2 сая төгрөгийн төсөв батлагдсанаас 19,661.1 сая төгрөгийг урсгал зардалд, 1,314.1 сая төгрөгийг хөрөнгийн зардалд зарцуулахаар батлагджээ.

Нийт зардлын 17,035.7 сая төгрөгийг улсын төсвөөс, 3,689.3-1 сая төгрөгийг орон нутгийн төсвөөс, 30.8 сая төгрөгийг оны эхний үлдэгдлээс, 7.2 сая төгрөгийг үндсэн болон туслах үйл ажиллагааны орлогоос, 12,2 сая төгрөгийг аймгийн орон нутгийн хөгжлийн сангаас, 200.2 сая төгрөгийг эргэн төлөгдөх зээлээс санхүүжүүлэхээр төлөвлөжээ.

Гүйцэтгэлээр улсын төсвөөс 17,035.7 сая төгрөгийн, орон нутгийн төсвөөс 3,689.2 сая төгрөгийн, аймгийн орон нутгийн хөгжлийн сангаас 12,2 сая төгрөгийн санхүүжилтийг бүрэн олгосон байна.

Эргэн төлөгдөх зээлээс 200.2 сая төгрөгийн орлого бүрдүүлэхээс 114.8 сая төгрөгийн гүйцэтгэлтэй байгаа нь сум хөгжлийн сангийн авлага хугацаандаа төлөгдөөгүйтэй холбоотой байна.

Туслах үйл ажиллагааны орлогод 8.5 сая төгрөгийг бүрдүүлж, батлагдсан төсвөөс 1.3 сая төгрөгөөр давсан байна.

Төсвийн нийт зардлын гүйцэтгэл 20,806.9 сая төгрөг буюу 99.2 хувьтай байгаа нь [батлагдсан](#) орон тоо дутуу ажилласантай холбоотой байна.

**Нэмэлт төсөв:** Дээд шатны төсвийн захирагчаас доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө 407.1 сая төгрөг, үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого 124.9 сая төгрөг, нийт 531.9 сая төгрөгийн орлогыг бүрдүүлжээ.

Үүнээс: Цалин хөлс, НДШ-ийн зардалд 9.5 сая төгрөг, тогтмол зардалд 2.7 сая төгрөг, хангамж, бараа материалын зардалд 84.6 сая төгрөг, урсгал засварын зардалд 46.8 сая төгрөг, томилолтын зардалд 4.9 сая төгрөг, бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамжийн зардалд /хэлмэгдэгсэд нөхөн олговор/ 248.9 сая төгрөг, хичээл үйлдвэрлэлийн дадлагын зардалд 131.2 сая төгрөг, нэг удаагийн тэтгэмж урамшууллын зардалд 3.4 сая төгрөг, нийт 531.9 сая төгрөгийг зарцуулсан байна.

## 2.10. ДАРААГИЙН АУДИТААР АВЧ ҮЗЭХ БУЮУ АНХААРАЛ ТАТАХУЙЦ БУСАД ЧУХАЛ АСУУДАЛ

1. Сумдын засаг дарга нар нь Засаг даргын нөөцийн хөрөнгийн зориулалт, зарцуулалтын журам"-д \_\_\_\_\_хамаарахгүй, урьдчилан төлөвлөх боломжтой, нэг удаагийн бус шинж

ДОА-2020/12/СТА-ТТЗ



Хэрлэн сумын 2019 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, жилийн төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

чанартай\_—арга хэмжээнд зарцуулахаар захирамж гаргаж байгааг анхаарах шаардлагатай байна.

2. Урт хугацаат өр төлбөрийн дансны үлдэгдэлд 2005 онд “Чойбалсан хөгжил” ОНӨҮГ нь “Дорнод НАА” ОНӨААТҮГ-аас бие даан үйл ажиллагаа явуулж эхэлсэнтэй холбоотой үүссэн өр байна. Дээрх урт хугацаат өр төлбөрт зохион байгуулалтын арга хэмжээ авч ажиллах шаардлагатай байна.

#### 2.11. Шилэн дансны мэдээлэл

Хэрлэн сумын төсвийн төвлөрүүлэн захирагч Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан 131 мэдээлэл оруулахаас 129 мэдээллийг хугацаанд нь байршуулан, 2 мэдээлэлийн хугацаа болоогүй байна.

#### 2.12. Өмнөх зөвлөмжийн хэрэгжилтийн талаарх тайлбар, тодруулга

Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар төсвийн төвлөрүүлэн захирагчийн тайланд хийсэн аудитаар алдаа, зөрчил илрээгүй тул зөвлөмж өгөөгүй байна

#### 2.13. Дүгнэлтийн хэлбэр, үндэслэл

Бид Хэрлэн сумын 2019 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайланд аудит хийж, баталгаажуулах ажлыг АДБОУС-ын дагуу, Монгол Улсын холбогдох хууль тогтоомжид нийцүүлэн гүйцэтгэсэн.

Хэрлэн сумын 2019 оны жилийн эцсийн санхүүгийн нэгтгэсэн байдал, санхүүгийн нэгтгэсэн үр дүн, нэгтгэсэн мөнгөн гүйлгээ, нэгтгэсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, төсвийн гүйцэтгэлийн тайлан болон бусад илчлэл тодруулгад тайлагнасан үлдэгдэл, ажил гүйлгээнүүдийг холбогдох хууль, УСНББОУС, түүнд нийцүүлэн Сангийн сайдын баталсан заавар, журмуудын дагуу материаллаг байдлын хувьд алдаагүй, үнэн зөв, шударга илэрхийлсэн эсэхийг Аудитын гэрчилгээнд тодорхой дурдав.

Аудитын гэрчилгээг энэ тайлангийн 1 дүгээр хэсэгт үзүүлэв.

Field Code Changed

Field Code Changed

### **3. Менежментийн захидал**

Төрийн аудитын байгууллага санхүүгийн тайлангийн аудит бүрийн төгсгөлд аудитаар илрүүлсэн зүйлсийг нэгтгэсэн менежментийн захидлыг үйлчлүүлэгч, түүний удирдлагад зориулж бэлтгэдэг бөгөөд түүнд санхүү, нягтлан бодох бүртгэл, тайлагналын бодлого, үйл ажиллагаа, дотоод хяналтыг сайжруулах зөвлөмжийг тусгадаг.

Энэхүү менежментийн захидлын агуулга АДБОУС болон аудитын дүн, дүгнэлтээс урган гарсан болно. Санхүүгийн тайлан, бусад илчлэл тодруулгын талаар санал дүгнэлт гаргахад бидний бодлого, горим зориулагдсан.

Энэ нь Хэрлэн сумын төвлөрүүлэн захирагчийн нягтлан бодох бүртгэлийн бодлого, горимыг зөвхөн аудитыг үр нөлөөтэй гүйцэтгэхэд шаардагдах цар хүрээнд дахин хянасан бөгөөд оршиж буй бүх сул талыг гаргаж ирэх боломжгүй юм.

Тиймээс аудитын тайланд тусгасан зөвлөмж нь аудит хийх үеийн нөхцөл байдлын талаарх бидний үнэлэлт, дүгнэлтийг илэрхийлж байгаа болно.

Харин эдгээр зөвлөмжийг та бидний хамтын ажиллагааны байр сууринаас гаргасан бөгөөд аудитаар өгсөн зөвлөмжийг хүлээн авч, хэрэгжүүлэх нь танай үүрэг хариуцлага юм.

Менежментийн захидалд дурдсан цаашид санхүүгийн нэгтгэсэн тайланд шууд бөгөөд материаллаг хэмжээгээр нөлөөлж болзошгүй тул анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлоор нь эрэмбэлэн үзүүлэв. Үүнд:

#### **3.1 Дотоод хяналттай холбоотой асуудал**

3.1.1 Илрүүлэлт: Сумын төсвийг өргөн мэдүүлэхдээ "Засаг даргын нөөцийн хөрөнгийн зориулалт, зарцуулалтын журам"-д хамаарахгүй, урьдчилан төлөвлөх боломжтой, нэг удаагийн бус шинж чанартай арга хэмжээнд төлөвлөн зарцуулж байна.

3.1.2 Эрсдэл: Зардал үр ашиггүй, зориулалт бусаар зарцуулагдах

3.1.3 Өгсөн зөвлөмж: "Засаг даргын нөөцийн хөрөнгийн зориулалт, зарцуулалтын журам"-ыг мөрдөж ажиллах.

3.1.4 Байгууллагаас өгсөн хариу, тайлбар: Зөвлөмжийг хэрэгжүүлэн ажиллана.

Дээрх зөвлөмжийн биелэлтийг Дорнод аймаг дахь Төрийн аудитын газарт 2020 оны 9 дүгээр сарын 1-ний дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

Хэрлэн сумын 2019 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, жилийн төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

4. Аудит хийсэн санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайлан

Formatted: Font: Bold

4.1 Аудит хийсэн санхүүгийн нэгтгэсэн байдлын тайлан

2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

(мянган төгрөгөөр)

Дансны код	Балансын үзүүлэлт	Эцсийн үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
<b>1</b>	<b>ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН</b>	<b>3 492 893 387.79</b>	<b>4 008 121 184.37</b>
<b>31</b>	<b>МӨНГӨН ХӨРӨНГӨ</b>	328 809 030,88	385 602 842,03
<b>311</b>	<b>Кассанд байгаа бэлэн мөнгө</b>	98 416,32	78 427,21
31110	Төгрөг	98 416,32	78 427,21
<b>312</b>	<b>Банкинд байгаа бэлэн мөнгө</b>	328 710 614,56	385 524 414,82
<b>3121</b>	<b>Төгрөг</b>	328 710 614,56	385 524 414,82
31211	Төрийн сангийн харилцах	328 181 781,92	379 745 393,09
31213	Арилжааны банк дахь харилцах	528 832,64	5 779 021,73
<b>33</b>	<b>АВЛАГА</b>	829 236 720,52	897 626 179,77
<b>335</b>	<b>Бусад авлага</b>	825 864 219,04	897 626 179,77
3351	Байгууллагаас авах авлага	334 495 360,04	434 846 234,99
3352	Хувь хүмүүсээс авах авлага	491 368 859,00	462 779 944,78
<b>35</b>	<b>БАРАА МАТЕРИАЛ</b>	2 334 847 636,39	2 724 892 162,57
<b>351</b>	<b>Түүхий эд материал</b>	104 486 077,77	228 921 584,46
35110	Тусгай зориулалттай материал	102 348 113,67	210 410 310,95
35130	Эм боох материал	2 137 964,10	18 511 273,51
<b>354</b>	<b>Хангамжийн материал</b>	2 157 882 597,00	2 424 138 286,49
35410	Бичиг хэргийн материал	25 936 901,50	25 463 042,50
35420	Аж ахуйн материал	317 067 529,36	339 155 885,52
35430	Сэлбэг хэрэгсэл	1 176 839,00	949 999,00
35440	Түлш, шатах тослох материал	-	3 645 000,00
35450	Барилгын засварын материал	727 000,00	3 466 000,00
35460	Хүнсний материал	1 435,00	3 619,50
35470	Бусад хангамжийн материал	1 812 972 892,14	2 051 454 739,97
35600	Мал амьтад	72 478 961,62	71 832 291,62
<b>2</b>	<b>ЭРГЭЛТИЙН БҮС ХӨРӨНГИЙН ДҮН</b>	<b>56 145 478 112.32</b>	<b>60 179 047 566.57</b>
<b>39</b>	<b>ҮНДСЭН ХӨРӨНГӨ</b>	56 145 478 112,32	60 179 047 566,57
<b>392</b>	<b>Биет хөрөнгө</b>	48 205 025 611,43	52 269 056 250,66
39201	Барилга, байгууламж, орон сууц	39 960 454 425,61	45 045 308 101,00
39202	Хуримтлагдсан элэгдэл	(1 451 697 373,46)	(2 849 988 899,08)
39203	Авто-тээврийн хэрэгсэл	1 339 712 942,40	1 617 726 569,06
39204	Хуримтлагдсан элэгдэл	(864 070 907,68)	(912 865 184,03)
39205	Машин тоног төхөөрөмж (компьютер)	3 010 481 749,78	3 268 990 416,77
39206	Хуримтлагдсан элэгдэл	(2 002 633 562,16)	(2 283 619 583,41)
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	1 595 979 456,35	1 790 041 148,48
39208	Хуримтлагдсан элэгдэл	(859 737 937,69)	(995 116 331,07)
39209	Зам, гүүрийн байгууламж	2 507 957 681,00	2 732 290 222,30
39210	Хуримтлагдсан элэгдэл	(351 732 894,53)	(535 524 170,54)
39213	Түүх соёл, музейн дурсгалт зүйлс	1 749 516 573,00	1 805 474 173,00
39214	Бусад үндсэн хөрөнгө	3 792 772 203,07	4 618 768 294,07
39215	Хуримтлагдсан элэгдэл	(964 021 509,04)	(1 353 212 472,35)
39216	Дуусаагүй барилга, байгууламж	714 254 160,46	314 254 160,46
39217	Ном	27 790 604,32	6 529 806,00
<b>393</b>	<b>Биет бус хөрөнгө</b>	7 940 452 500,89	7 909 991 315,91
39301	Програм хангамж	35 025 691,41	37 820 364,41
39302	Хуримтлагдсан элэгдэл	(28 135 386,58)	(29 611 845,14)
39303	Бусад биет бус хөрөнгө	7 987 175 995,00	7 987 175 995,00
39304	Хуримтлагдсан элэгдэл	(53 613 798,94)	(85 393 198,36)
<b>3</b>	<b>НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III-I+II</b>	<b>59 638 371 500.11</b>	<b>64 187 168 750.94</b>



Хэрлэн сумын 2019 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, жилийн төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

4	<b>НИЙТ ӨР ТӨЛБӨР</b>	<b>265 603 327,09</b>	<b>163 080 440,46</b>
41	<b>БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР</b>	265 603 327,09	163 080 440,46
